



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 237

Мандалговь

┌ Хөрөнгө худалдах тухай ┐

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам"-ын 3.1.б, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Хулд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2'978'930 /хоёр сая есөн зуун далан найман мянга есөн зуун гуч /төгрөгийн анхны ертөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн наадмын талбайн барилгыг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 500'000 /таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Хулд сумын ЗДТГ-ын дарга Н.Баярсайханд даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100430